

## ӨЧИГ МЭДҮҮЛГЭЭС ҮНЭНИЙГ МӨШГӨХ НЬ

Д.Хүүхэнбаатар

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

**Өгүүллийн төвч утга:** Монголд Зөвлөлтийг сталинизмыг эсэргүүцсэн хүчин зорилго, бодлоготой үйл ажиллагаа явуулж, тэмцэж байсан гэсэн санааг Ерөнхий сайд А.Амарын мэдүүлэг, Японд очсон оргодол Бямбаагийн тэмдэглэл болон бусад баримт сэлт дээр тулгуурлан өгүүлжээ.

**Тулхүүр үг:** Аллага, хэлмэгдүүлэлт, түүхэн үнэн, үндэсний эрх ашиг, мэдүүлэг, Их Монгол улс хэмзэх байгууллага, Зөвлөлтийнхэн, сталинизм.

1930-аад оны сүүлчээр (1937-1939) Монгол улсад учирсан аймшигт цуст аллага (их хэлмэгдүүлэлт гэж ч нэрлэдэг) чухам юуны учир болов?, яагаад монголчууд буруутан тэrsүүд дайсан болж, үхэл сүйрлийн зууш болов гэдэг асуудал өөрийн эрхгүй гарч байна. Оргүй газар юуг шалтаг болгов.

Оросууд өөрийн орондоо явуулсан аймшигт яргаллаа монголд яах гэж экспортолсон юм бэ?

Монголчууд оросын дарангуйллыг тэгтлээ хүлцэнгүй өвдөг сөхрөн хүлээж байсан гэж үү!

Үнэний үүднээс нягтлан үзэх ахул эрс өөр түүхэн үнэн гарч ирнэ. Их Оросын мөн чанарыг монголчууд эртээс мэдэж ойлгож сөрөг бодлого явуулж тэр нь уламжилсаар өдий хүрчээ. Мэдсээр атлаа Оросыг шүтэж түшэхээс өөр гарц байхгүй гэдгээ ч монголчууд ойлгож байсан. Юм бүхэн цагтай, хязгаартай байдаг болохоор түүх, мэдэн тэвчихээс эсэргүүцэн тэмцэхэд гарцаагүй хүргэсэн юм.

Монголчууд түүхийн үе бүхнээ жинхэнэ тусгаар тогтносон, биеэ даасан, бусдын хараат биш Монгол улсын төлөө тэмцэж ирсэн тэр хүсэл эрмэлзлэл, бодол ухаан, үйлс тэмцлийн туг нь Их Монголын үндэсний үзэл мөн . Түүнийхээ сүр сүлд болгож, аугаа суут их хүн Чингис хаанаа өргөн дээдэлдэг юм. Гэлээ ч манай энэ шударга шулуун үнэн хүсэл эрмэлзлэл, зорилго маань ёсоороо хэрэгжин биелж байгаагүй нь түүхийн гуниг гамшиг гэхээс өөрөөр хэлэмгүй. Гэвч Монголчууд тэнгэрлэг ард түмэн гэдгийг дэлхий зөвшөөрдгийг мартаж, огоорч болохгүй, бас даварч хэтрүүлж болохгүй.

Монголын үндэсний үзэл нь хүмүүсийн сэтгэл санаанд нуугдмал байгаагүй. Цэгцэрсэн үзэл бодлого, төдийгүй үйл ажиллагаа байжээ. Чухам үүнийг Улааны хэт хувьсгалчирхаг харгис хүчин далим шалтаг болгож, Японы тагнуул, хувьсгалын эсэргүү нэр хаяг зүүж, нэр усы нь жагсааж нийтээр нь хомроголон устгах цуст шуурган компани дэгдээжээ.

Ийм аргаар Оросын эсрэг үндэс угсаагаа, Монголоо гэсэн бүгдийг толгой дараалан хядан дарж авч зөвхөн өөрсдийгээ дэмжигчид, аялдан дагалдагчдыг хөхүүлэн дэмжиж, нэр төдий тоглоомын бүрэн хараат, улс болгоход чиглэгджээ.

Энэ бүхнийг монголчууд санаачлан хийгээгүй, гаднын хүчин, улаан оросууд, Сталины зандалчид үйлдсэн гэдэг нь одоо нэгэнт бүхэнд илэрхий. Чойбалсан, түүний хүрээллийнхэн бол зөвхөн Улаан оросын гар хурууны үзүүр төдий, хөөрхийлөлтэй, өөрийн мэдэлгүй, өөрийн толгойгүй тоглоомын хүүхэлдэйнүүд байсан юм.

Үнэнийг мэшгөхөд, хэргээ хүлээж байсан нь тулгалт, зохиомол зүйл бөгөөд үндэсний эх орончид өөрсдийн ариун шударга тэмцлээ нэгд нэгэнгүй тоочоод бидний энэ үйл хэрэг японы тагнуул, хувьсгалын эсэргүү хэрэг байжээ гэж хуурмагаар зөвшөөрсөн юм шиг байдаг. Энэ нь нэг талаас цаашид улс орныхоо төлөө тэмцэхийн төлөөнөө амиа авч үлдэх гарц байсан гэхэд үгүй гэхийн аргагүй.

Нягтлан бодоход, Монголд Зөвлөлтийг, Сталинизмийг эсэргүүцсэн зорилго, бодлоготой хүчин үйл ажиллагаагаа явуулж тэмцсээр 1930-аад оны

сүүлчээр туйлдаа хүрсэн нь тодорхой. Хувьсгалын эхний 20 жилийн үйл явц үүнийг бэлээхэн нотолж байна.

Эрдэмтэн Ж.Болдбаатар "Монголчууд дасан зохицох, үлдэж хоцрох гойд чадвартайн шинж"<sup>1</sup>-ийг тодорхойлсон нь судлаачдын анхаарлыг татаж байна. Нээрээ л "... хоёр аугаа их үндэстэнтэй зэрэгцэн оршиж, зарим үед нэгэн гүрний бүрэлдэхүүнд багтаж, "ойртон нягтарч" явсан ч уусч алдраагүй удмын сангaa хадгалж үлдсэн нь гайхалтай бус уу<sup>2</sup> гэсэн нь Халх төвт Монголд хамааруулжээ. Оросын буриад, халимаг, Хятадын өвөр монгол, барга нар бүрэлдэхүүнд нь багтсаар суурьшмал соёлын нөлөөн дор явж ирсэн авч монголоо бүрэн алдаагүй ирсэн нь ч нэгийг өгүүлсээр байна.

Улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртөн "хувьсгалын эсэргүү", "Японы тагнуул" гэгдэгчид болсон хүмүүсийн зарим өчиг мэдүүлэг, тэр үеийн байдлыг сайн мэдэх хүний үлдээсэн тэмдэглэлээс үнэн нь хаанаа байгааг олоход баримтыг нягплахад сонирхолтой нь эсэргүү, тагнуулын хэргийг отхон ч зөвшөөрөгүй, харин жинхэнэ бие даасан тусгаар тогтоносон их монгол улс байгуулах үзэл бодол, үйл ажиллагаагаа зөв гэж хамгаалсан байна.

А.Амар, түүнийг таслан шийтгэсэн хурал дээр хэлэхдээ: "Монголын нутаг дэвсгэрт хувьсгалын эсэргүү ямарч бүлгэм байгаагүй бөгөөд аргагүйн эрхэнд нэрлэсэн хүмүүс нь хувьсгалын эсэргүү ямар ч хэрэг үйлдээгүй юм шүү"<sup>3</sup> гэж эрс тууштай мэдэгдсэн юм.

Энэ бол хамтран тэмцэгчидээ Монголынхoo тусгаар тогтнолын төлөө зориглон боссон үндэсний эх орончид байсан гэдгийг зоримог хамгаалсан хэрэг мөн хaa ч нийтлэгдээгүй А.Амарын "мэдүүлэг"-ийг зохиолч Лха.Дарьсүрэн 1995 онд нийтлүүлж судалгаанд оруулж ирсэн байна<sup>4</sup>.

Тэрээр уг "мэдүүлэг"-ийг бичүүлсэн гэж үзэхэд эргэлзээтэй гэсэн байна. Бичлэгийн хэв маяг үсэг зурлага нь ч А.Амарых мөн нь гарцаагүй бөгөөд мэдүүлгийн төгсгэлд "Энэхүү мэдүүлэг миний өөрийн гараар бичигдсэн үнэн. Үүний доторхи засвар нэмэлтүүд цөм миний өөрийн гараар гүйцэтгэсэн болой. Амар<sup>5</sup> гэсэн нь бас нэгэн зүйлийг нотлох мэт.

Тэр чухам өөрийгөө буруутган хүлээсэн мэдүүлгийн цаад зорилго, агуулга далд санааг шинжин үзэхэд түүний өөрийгөө гэмтэнд үзэж хүлээсэн бухэн нь хувьсгалын эсэргүү, Японы тагнуулын хэрэгт огт холбогдохгүй бөгөөд Монголын жинхэнэ тусгаар тогтнол, үндэсний ардчилсан хувьсгалын зорилтыг зөв замаар нь хөгжүүлэхийн төлөө хийсэн тэмцэл харагдаж байна. Мэдүүлэг дахь зүйлүүд нь бусад мэдүүлэг, тэмдэглэлтэй тохирдог, түүний үнэн болохыг нотлох учир бид тэдгээр баримтаас заримыг ашигласан болно. Тухайлбал Б.Ренчиний<sup>6</sup> өчиг мэдүүлэг, Бямба<sup>7</sup> гэгчийн бичиж үлдээсэн тэмдэглэл юм. Мөн зарим судлаачид, хэвлэлийн саналыг анзаарсан болно<sup>8</sup>. Зарим санаа дүгнэлтийг иш татъя.

Түүхч Б.Банзрагч "Оргодол Бямбаагийн тэмдэглэлийг уншихад түүнд өгүүлсэн зүйлс нь эхнээсээ эцсээ хүртэл тэр аяараа худал зохиомол нь үзтэл илэрхий болохоос гадна тэр тэмдэглэл нь чухам ямар нөхцөлд хэрхэн яаж бэлтгэгдэж гарсаныг мэдэхэд ч түвэргүй байна<sup>9</sup> гэжээ. Энд эхнээсээ эцсээ хүртэл тэр аяараа худал гэдгийг бүрэн зөвшөөрөх аргагүй, тэр үед монголд болж байсан олон үйл явдлыг үнэнээр бичсэн байdag. Харин ямар нөхцөлд бичигдэв гэдэгт

<sup>1</sup> Ж.Болдбаатар. Дэлхий дахины болон нутгийн түүхэнд Монголчуудын гүйцэтгэсэн үүрэг. УБ. 2003 он. 47 тал

<sup>2</sup> Мөн тэнд.

<sup>3</sup> Ж.Болдбаатар. "Амар сайд" Булган хот. 1993. 57 тал

<sup>4</sup> ЗГМ сонин. 1996. № 53 (493) Үнэн. 1995 № 15 (18379)

<sup>5</sup> Үнэн. 1995. № 15 (18379)

<sup>6</sup> Монголын залуучууд. 1991. №22 (7600) Г.Дүйхаржав. Шоронд өнгөрсөн таван жил. 1991. УБ

<sup>7</sup> Гадаад Монголоос 1939 онд зугатан гарсан Бямбаагийн тэмдэглэл. Эрдэнийн эрих. 1991. № 2-4

<sup>8</sup> "Эрдэнийн эрих" 1991. №5(9) ЗГМ., 1993 №134 (276)

<sup>9</sup> Үнэн сонин. 1991. № 109

анхаарах нь зүйтэй. 2 сарын турш бичүүлсэн тэрхүү тэмдэглэлийг японы цэргийнхний шахалтаар гарсан гэдэг нь ч үнэн юм. Япончууд тэмдэглэлийг бичүүлсэн, зөвлөж байсан нь ч үнэн. Тэгээд японоор хэвлүүлсэн нь ч сонин.

Гэвч монголоо гэсэн сэтгэлтэй монгол хүн болохоор тэр үеийн монголын төрх байдлыг байгаагаар нь үнэнд ойртуулж бичсэн талтай гэх үндэстэй.

Д.Чойжамц "... Ер Бямбаагийн тэмдэглэлд өгүүлсэн зүйл Б.Ренчингийн мэдүүлэгт өгүүлсэн зүйл хоёр үндсэндээ нийлж байгаа юм. Үүнд аль алинд нь Зөвлөлтийн эрхшээлээс гарах гэсэн үйл ажиллагаа ч өгүүлжээ<sup>10</sup> хэмээн дүгнэсэн байна. Энэ бодит үнэнийг ор тас үгүйсгэж болохгүй давхар нотолно. Түүгээр ч үл барам Д.Чойжамц "хувьсгалын эсэргүү байгууллага монголд байсан уу", хэмээх тэрхүү өгүүллэгтээ: "... Зөвлөлтийн даралт хавчилтад эрс дургүйцсэн эх орноо Азийн хүчирхэг улс Японы тусламжтайгаар зөвлөлтийн нөлөөнөөс ангижруулан нэгдсэн их Монгол улс байгуулах, жинхэнэ өсөөр биеэ даасан. Гадаад Монгол улс байгуулах гэсэн нууц хөдөлгөөн өрнөсөн бололтой юм"<sup>11</sup>, гэсэн дүгнэлттэй миний санаа нэг байгаа юм.

Хэвлэлийнхэн (Эрдэнийн эрих) Бямбаагийн тэмдэглэл, зарим материалын үүдэн огт үгүйсгээгүй, буруутгаагүй, юу олж мэдсэнээ нийтлүүлэн, санаа бодлоо илэрхийлсэний дотор "... Чойбалсан тэргүүтэй "Хувьсгалчад", "хувьсгалын эсэргүү" Гэндэн, Дэмид, "Малжийн хэрэг" гэгчийгээ нотлох нэн чухал материал байж болох юм" гээд Орост тоглосон эмгэнэлт драмын жүжгийн монгол хувилбарыг манайхан өөрийн тайлан дээр тоглосон ч байж болзошгүй<sup>12</sup> хэмээн цаашдын гүнзгий судалгаа хийхийн чухлыг тэмдэглэжээ.

Үүнийг үгүйсгэхийн аргагүй. А.Амарын мэдүүлгийг сөхөхийн өмнө Б.Ренчин амиа авч үлдэхийн төлөө худлаа өчиж үү? үнэн мөнөө улс орныхоо төлөөнөө өчиж үү? гэдгийг эрх биш харгалзууштай. Б.Ренчин агсаны улс төрийн хэргээр баривчлагдаад 1937, 1940, 1941 онуудад өгсөн мэдүүлгүүд, "Намын Төв Хорооны тусгай комисст" илгээсэн бичиг, 1956 онд өөрийн хэргийн талаар өгсөн ярилцлага зэрээс үзэхэд олон зүйлийг тодорхой болгож худал хуурмаг гэхийн аргагүй нь мэдэгдэнэ. Тэрээр маш тодорхой нэртэй устай нь, газар оронтой нь явуулж байсан үйл ажиллагаагаа нэгд нэггүй өгүүлж баримтаар баталсан байна.

Б.Ренчин 1937 оны мэдүүлэгтээ Японы тусламжтайгаар нэгдсэн Их Монгол Улс байгуулах зорилго бүхий нууц байгууллага байсан тухай маш тодорхой өгүүлжээ. Үг байгууллагын гишүүд 40 гаруй хүний нэр ус, ажил төрлийг нэрлэж, байгууллагын удирдах төвийг Улаанбаатар, Улаан-Үд, Москва, Ленинград, Парис, Берлин хотуудыг зааж тэнд хэн хэн байгааг нэр зааж мэдэгджээ<sup>13</sup>. Г.Дүйнхэржавын судалгаанаас үзэхэд Б.Ренчин гуай Дамбадорж, Жадамбаа, Цэрэндорж, Амар, Буюннэмэх, Буян чуулган, Дэндэв нарын 15-16 хүний нэрийг дурьдаад "Их Монгол улс байгуулах зорилгоор ажиллаж буй амуй"<sup>14</sup> хэмээн маш тодорхой өгүүлжээ.

Байгууллагын удирдлагад Ц.Жамсранов, А.Амар тэдний удирдлагаар Б.Ренчин ажилладгаа өгүүлээд тэдний даалгавраар хийсэн бүтээснээ дурдаад энэ хөдөлгөөний нэртэй зүтгэлтнүүд мэргэн гүн Гомбожав, Элбэгдорж Ренчино нарыг хүндлэн үнэлж, тус байгууллагын гадаад дахь гишүүдэд Павел Пелио, Дорж, Буриад монголын Вандангийн Батмөнх, Ринчины Гомбо зэрэг олон хүний нэрийг дурьджаа<sup>15</sup>. Энд судлаач Д.Чойжамцын<sup>16</sup> судалгаа, хийсэн дүгнэлт, санаа оноо ихээхэн сонирхолтой бөгөөд би үнэн гэж ишлэл болгон оруулж байгаа юм.

<sup>10</sup> ЗГМ. 1995. №134 (576)

<sup>11</sup> ЗГМ. Мөн дугаар

<sup>12</sup> ЗГМ. Мөн дугаар

<sup>13</sup> ЗГМ. Мөн дугаар

<sup>14</sup> ЗГМ сонин 1991. № 22 (7600)

<sup>15</sup> ЗГМ сонин 1995. № 134 (376)

<sup>16</sup> Мөн тэнд

Дээр дурьдсан материалуудыг харьцуулан шинжихэд гол гол хэрэг явдал, байдалд хийсэн **дүгнэлтүүд** нь зөрөх зүйлгүй тохирч байгаа бөгөөд тухайн үеийн монгол орныг үнэнээр нь нэмэр хачиргүй тоочин гаргасан байна. Тэдний тоочиж байгаа зүйлүүд үнэхээр амьдралд болсоныг түүхэн хэрэг явдал нотолж байгаа юм.

Д.Чойжамц, Ренчиний мэдүүлгийг үнэний үндэстэй гэх хэд хэдэн онцлог шинжээр гаргаж тавьжээ. Түүний мэдүүлэг нь өөрийн ажиллагааг эмх цэгтэй, дэс дараатай дэлгэрэнгүй хүүрнэн өгүүлсэн, мэдүүлэгт тухайн үед баривчлагдаагүй байсан олон хүний үйл ажиллагааг нууц үйл ажилд баримттай хамааруулан дурьдсан, Ц.Жамсрановын Их Монгол улсыг байгуулах хэмээсэн ажил явууллагад багтальсан орох саналыг өгч зөвшөөрсөн хөдөлбөргүй (1927 он) үнэнээ хуурмаггүйгээр хэд хэдэн удаа давтсан байдаг. Бүр 1942 онд ч маршал Чойбалсан, Цэдэнбал нарын “чамд хэрэг бий юу?” гэж асуухад тэрээр “жаал жуул юм бий болов уу?” “бага сага холбогдолтой байсан” гэж өөрийгөө хаацайлалгүй, үндэс угсаагаа аврахын төлөө үйлст хүчин зүтгэсэн хэрэг гэдгээ зоригтой илэрхийжээ.

Д.Чойжамцын бас нэг санаа бол Б.Рэнчингийн мэдүүлгийг тухайн үеийнхээ хэрэг явдуудад холбогдож байгаа нь улам их үнэний үндэстэй болгож байна гэжээ. Тэрээр, Герман, Францад залуучуудыг явуулж сургаж байсан нь өөрсдийн хойч үе, залгамжлан тэмцэгч шинэ хүчин, эх орончдыг бэлтгэж байсан гэсэн санаа нь анхаарал татаж байна.

Б.Ренчиний мэдүүлэгт илэрхийлж буй үзэл бодол Бямбаагийн тэмдэглэлд нэгэн адил өгүүлэгдэж байгаа нь бас л нэг үнэний баталгаа бус уу? гэсэн байна. Амиа аврахын тулд тамлан эрүүдэхийн зовлонгоос худал хэрэг хүлээсэн гэхэд дэндүү мөчид дүгнэлт бөгөөд судлаачдын тэр үеийн тэмцэл хөдөлгөөний жинхэнэ үнэнийг нягтлан нарийвчлан судалж зохих байр суурий нь эзлүүлж дүгнэлт өгөх нь чухлаар шаардагдаж байна. Бас нэг цоо шинээр ажиглагдаж байгаа зүйл бол А.Амар ч, Б.Рэнчингийн мэдүүлэг, Бямбаагийн тэмдэглэлд ч монголчуудын нэгдсэн Их Монгол Улс байгуулах бодлого уг хөдөлгөөний түүхэн хөгжлийг маш тодорхой тавьж, дор бүрнээ үнэлэлт дүгнэлтээ хийсэн байна.

Энэ бол судалгааны цоо шинэ урд хэн ч хэлж байгаагүй бодит үйл явдлыг монголчуудын ХХ зуунд явуулсан хурц тэмцэл гэдгийг зөвшөөрч зохих байр сууринд нь тавих нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, өнөөгийн судалгааны түвшинд улс төрийн хядлага, их хэлмэгдүүлэлтэд гэм буруугүй учир цагаатгагдсан гэж асуудлыг нэг талаас нь авч үзэх төдий байгаа бөгөөд нөгөө талаас эсэргүүцэн тэмцсэн үндэсний эх орончдын үйл ажиллагааг товтой гаргаж тавьж чадаагүй байна.

Цагаатгал гэдэг нь “хувьсгалын эсэргүү”, “Японы тагнуул” байдаггүйг шударгаар нотлон баталсан ариун үйл ажил бөгөөд нийт ард иргэд, хүүхэд, залуучуудыг монголоо гэсэн эх оронч үзэл, эх түүхээрээ хүмүүжүүлэхэд чухал ач холбогдолтой. Нэгдсэн Их Монгол улс байгуулахын төлөө манай үндэсний хувьсгалч эх орончдын тэмцлийг “цагаатгаагүй” билээ.

Ер нь энэ байгууллагынхан эх түүхээ судлах, нийтэд хүртээл болгож, түүгээрээ бахархах үзлээр хүмүүжүүлэхэд онцгой ач холбогдол өгч энэ талаар их зүйл хийсэн байна. Ер улируулан үзэхүл өвөг дээдэс ард түмэн маань түүхэн хөгжлийн үе шат бүхэнд эх түүхээ тасралтгүй бүтээн туурвисаар ирсэн нь үндэсний тусгаар тогтолын бэлэг тэмдэгийн илрэл болж байлаа.

Б.Ренчиний мэдүүлсэнээр түүхээ судлах, зохиох ажилд шамдаж, их монгол улс байгуулах санааг дэлгэрүүлэх зорилгоор Ленинградын Грумм Гржимайло гэдэг эрдэмтнээр “их монголын сургууль”-ийг байгуулж, монголын

түүхийг зохиолгосон<sup>17</sup>, А.Амар монголын түүхийг<sup>18</sup> бичиж хэвлүүлсэн нь ийм учир начиртай байжээ. Л.Дэндэв<sup>19</sup>, Х.Чойбалсан, Г.Дэмид, Д.Лосол<sup>20</sup> нарын түүх хэвлэгдэж, Б.Буянчуулган<sup>21</sup> түүхээ бичиж үлдээсэн нь ийн буюу.

Мөн Японы үндсэн хуулийг орчуулж, бичмэл дэвтрээр тараасан Японы нэгэн түүхчийн Монголын түүхийг орчуулсан, Монголын олон үеийн газрын зургийг Японд өгсөн, Чингис, түүний эдэлж хэрэглэж байсан зүйлсийг эрхэмлэн хадгалж цуглуулах, Өгөдэй, Өгөдэйн хатны зурагтай марк хэвлүүлэхээр завдаж, латин үсгийг хэрэглэхийг зогсоосон байна. С.Буяннэмэхээр "Баатар хөвгүүн Тэмүжин" хэмээх жүжгийг зохиолгожээ. Өөрсдийн залгамжлагч шинэ үеэз бэлтгэхэд анхаарч, гадаад улсуудад залуусыг явуулж сургаж байсныг дээр өгүүлсэн билээ. 1936 /26/ оны эхээр гарсан "Шинэ толь" сэтгүүлийг ШУХ-ээс гаргаж Б.Ренчин эрхлэн хэвлүүлж түүндээ өөрийх нь өгүүлсэнээр "өөрийн эсэргүү угта бүхий өгүүлбэр бичиж үзэгч олны үзэл мэдрэлийг нам засгийн тогтоол бодлогыг үл биелүүлэх зүтг чиглүүлэн нийтэлж байсан<sup>22</sup> гэжээ. Тэрээр жишээ болгон ШУХ-ийн Хөдөө аж ахуйн тасгийн ажилтан Цэвэлийн "малын хашаа саравч барина хэмээх буюу хадлан өвсийг хадаж бэлтгэх нь дэмий ашиггүй хэрэг" гэсэн угта бүхий зүйлийг нийтэлж байжээ. 1936 оны /26/ 9 сард алдарт шатарч Санжаажамцын "Монгол шатар" ном гарч, түүнийг Амарт хүргэж өгөхөд түүний хэлсэн нь "Санжаажамц нь манай байгууллагын гишүүн байгаа юм" гэжээ. 1935 /25/ онд цэргийн улс төрийн газрын дарга Дашичирэвийн даалгавараар монгол түүхээс улс болж явсан онуудыг түүвэрлэн гаргасан тухайд А.Амартай уулзахад "сайн байна" Дашичирэвийн манай байгууллагын хүн байгаа юм шүү" гэж хэлсэн байна.

Түүний даалгавараар Бор шувуу Ц.Дамдинсүрэнг элсүүлсэнээ ч тодорхой хэлсэн байна. Бас мэргэн гүн Гомбожавыг дагаж явахыг зөвлөсөн байх юм. Хүрээлэнгийн ажилтан мөөг Содномыг элсүүлсэнээ ч бичжээ. Анхаарал татаж байгаа бас нэг зүйл бол Рөнчин ба өөрөө тагнуулын харилцаа барьж яваагүй гээд Амар нараас намайг соёлын талаар энэ хэрэгт туслалцааас бус энэ хэргийн улс төрийн зорилгод орж ажилласны хэрэггүй хэмээн хэлдэг байсныг цохон дурьджээ.

Зохиолч Д.Цэдэвийн олж ирж хэвлүүлсэн "Гадаад Монголоос 1938 онд зутган гарсан Бямбаагийн тэмдэглэл"-ийг бүгд худал гэж бүрмөсөн үгүйсгэж болохгүй, хянах нягталж үнэмшилтэй шинэ мэдээ, баримтыг дэгс догосоос нь салгаж нэгдсэн Их Монгол Улс байгуулах хөдөлгөөний түүхэнд нөхвөр болгон ашиглаж болох юм. Д.Цэдэвийн "улс гүрний харилцааны түүхийг зөвхөн нэг талын материал дээр тулгуурлан ойлгох, дүгнэх явдал бодит байдлаас зарим талаар хэлбийж болох тул аль ч талын ямар ч материалыг элдэв засвар тайлбар хийлгүй үндсэн эхээр нь уншиж судлах явдал ардчилал ил тодыг эрхэмлэх болсон өнөө үеийн үзэл санаатай яв цав тохирох болов уу?"<sup>23</sup> гэсэнтэй үүнийг тэрлэгч миний бие санал нийлж байгаа бөгөөд нэмэр болох зорилгоор энэхүү баримтыг бусад шинээр олдсон "эсэргүү" гэгдсэн зарим хүмүүсийн тэмдэглэлийг харьцуулан жишиж үзэхийг оролдсон юм.

Оргож гарсан Бямбаагийн тэмдэглэлд юу өгүүлснийг товч боловч нягталж үзье. Түүний үзэл санаа зүшрэн тогтоход Нагац ах Самдан их нөлөө үзүүлсэн

<sup>17</sup> Грумм Гржимайло "Западная монголия" Урианхайский край. т.I.II б, т II Л, т III. вып. I-II . 1924. 1926. 1930

<sup>18</sup> А.Амар "Монголын товч түүх" УБ. 1969

<sup>19</sup> Л.Дэндэв "Монголын товч түүх" УБ. 1934

<sup>20</sup> Х.Чойбалсан, Г.Дэмид, Д.Лосол "Монголын ардын үндэсний хувьсгалын үүсч байгуулагдсан товч түүх" УБ. 1979

<sup>21</sup> Б.Буянчуулган "Манжаас Монголыг эзэрхийлсэн үеийг илэрхийлсэн хэрэглэгдхүүн" УННС. 1936

<sup>22</sup> "Монголын залуучууд" сонин. 1991. №22. /7600/

<sup>23</sup> "Эрдэнийн эрх" сонин. 1991 № 2/6/

бөгөөд “намайг үндэсний үзлийн амьсалаар амьсгалуулж өгсөн”<sup>24</sup> гэжээ. Самдан нь Хан үндэсний дарлалаас Гадаад Монголыг авран гаргахад зүтгэсэн хүний нэг гэж тодорхойлжээ. Бямбаа тэр үеийн Монголын улс төрийн амьдралыг улс төрийн хоёр бүлэглэл, тэмцэлдэж байгааг тодорхой баримтаар гаргажээ. Үүнд Монголчуудын үндэсний биеэ даасан гадаад Монгол гэсэн чиг баримтлах бүлэг, өөр нэг нь Зөвлөлтийн өөрчлөх, улаанчлах хүчийг ашиглан өөрөөр зохион байгуулах хэсэг бүлэг байв гэсэн нь үнэн гэх үндэстэй.

Үндэсний эх оронч, тусгаар тогтолын төлөө тэмцэгч I бүлэгт Дэмид, Гэндэн Малжаас гадна Дамба, Чоймбал, Сэндмаев, Даваабадамжав зэрэг хүмүүсийг нэрлэжээ. II бүлэгт Чойбалсан, Лувсаншарав нарыг нэр заажээ. Асуудлыг ингэж үзэх нь ул үндэстэй юм гэж үзнэ. Ер нь тусгаар тогтолын төлөө тэмцэгч үндэсний хувьсгалчдын бүлгийн үзэл бодол, зорилго, үйл ажиллагаа тэмцлийг түүх бичлэгт тод томруун тавьж, байр суурийн эзлүүлэн бие даасан сэдэв болгож сургалт, судалгаанд оруулах ёстой. Энд “Зөвлөлтийн эсрэг” үзлийн тухай, гарч ирж байгаа нь үндэстэй бөгөөд Сталины яргачид монголд яргалал явуулахдаа “Зөвлөлтийн эсрэг үзэлтэн” гэж буруутгасан зүйл байдаггүй нь “тагнуул”, эсэргүү нэр зүүж, нэдэр дээрээ тусгаар тогтоносон гадаад монгол бүлгийнхнийг бараг толгой дараалан устгасан нь зориудын зохион байгуулалтайгаар монголын үндэсний ардчилсан хувьсгал, тусгаар тогтолыг нухчин дарсан нүгэлт ялт хэрэг байлаа.

Бямбаагийн тэмдэглэлд байгаа хэлмэгдэгсдийн ажил үйлс, нэр ус нь цөм үнэн болох нь бусад материалтай тохирч байна. Бямбаа монгол, зөвлөлтөд цэргийн эрдэмд суралцаж, офицер болсон хүн бөгөөд монголын цэргийнхнээс тус байгууллагад оролцсон, тэдний гүйцэтгэсэн үйлсийг нэлээд ойроос мэдэх хүний хэрээр оруулсан гэж болно. Энэ бүхэн нь Москвагийн аймшигтай нарийн ажиллагаа юм гэсэн дүгнэлт нь одоогийн судлаачидтай дүйж байна. Зөвлөлтийн талыг баригч Чойбалсангийн бүлгийн эсрэг цэргүүдийн дотор зэр зэвсгээ эвдлэх, Ленин, Сталин, Чойбалсан, Лувсаншарав нарын зургийг урж хаяж байлаа. Цэргийн хоол хүнсийг муутгаснаас олноор өвчилж үхэж байсан, дулаан хувцсыг нь оройтуулж олгож байсан зэргийн эзний нь олох аргагүй гэсэн нь хачирхалтай санагдана.

Бямбаа зэвсэгт бослогод амжилттай бэлтгэж байсан тухай тусгайлан өгүүлж Малж, Дамба нарын тушаал заавраас иш татсанаас үзвэл Дорнод аймагт байгаа корпусын дөрвөн дивиз, Улаанбаатар дахь морин цэргийн I дивиз бослого гаргахаар бэлтгэгдсэн байна.

Тэд Японы армиар дэмжуулэх, Японы хүчийг Замын Үүдээр оруулж Улаанбаатар руу давшуулахыг эрмэлзэж байжээ<sup>25</sup>.

1930-аад оны сүүлчээр монголд зэвсэгт бослогод бэлтгэж байсан тухай МАХН-ын түүх, БНМАУ-ын түүх, хэлмэгдүүлэлттэй холбогдуулж бичсэн ном зохиолд, армийн түүхэнд ч олж үзсэнгүй.

Зэвсэгт бослогын тухай А.Амарын мэдүүлэгт их тодорхой өгүүлсэн байдгийг хойно өгүүлнэ. Чойбалсангийн бүлгийнхэн үүнийг тандаж мэдээд урьтаж Дэмид жанжин, Малж, Дамба нарын олон цэргийн зүтгэлтнүүдийг түүний хэлсэнээр бараг 1-2 өдөрт хорлон хядсан нь “нүд ирмэхийн зуур” болж, бослогыг урьтаж удирдлагагүй болгосон бололтой.

Бямбаа нь армийн жирийн офицер бөгөөд монголын тусгаар тогтолын төлөө сэтгэлтэй идэвхтэний нэгэн байсан бололтой. Ямар ч байсан армид нэгдсэн Их Монгол улс байгуулах бүлгийн идэвхтэй зүтгэлтнүүд ажиллаж, цэргүүдийн дунд дургүйцэх хөдөлгөөн байсныг үгүйсгэх аргагүй. Бямбаа бол эх орноосоо уравсан урвагч биш, аллага хядлагаас дайжиж, харь улсын хилийн

<sup>24</sup> Мөн тэнд.

<sup>25</sup> "Эрдэнийн эрих" сонин. 1991 №3

дээс алхаж бусдын гарт орсон хөөрхий нэгэн. Төрийн нэрт зүтгэлтэн, БНМАУ-ын ерөнхий сайд А.Амарын "мэдүүлэг" нь 4 үндсэн зүйлтэй бөгөөд тус бүрд нь юун тухай ухаан зарсныг нь мөшгин гаргахыг оролдож үзэв.

Өнгөц харвал А.Амар бүх буруугаа хүлээж, тоочин дэлгэсэн юм шиг харагдана. Яагаад ингэв гэдэг асуудал тавьж мөшгөвөл эрс өөр арга ухаан тодорч гарна.

Буруу бүхнийг өөртөө үүрээд үнэн хэрэгтээ Сталинизмын эсрэг үндсэний ардчилсан хувьсгалын шугамыг хамгаалан тэмцэж ирсэнээ ил тод илэрхийлсэн шинжийг агуулж байна. Энэ бол хойч үеийнхэндээ үлдээж, тэднийхээ гэгээн оюун ухаандаа тунгаан шүүхэд нь зориулсан болов уу гэлтэй. А.Амар, бид ийм үзэл бодолтой, улс үндэснийхээ төлөө ийм ажил үйлс бүтээснээ урвуу хэлбэрээр зөвийгөө буруутгах маягаар бичиж үлдээжээ гэж болно.

Зөв үйлсээ буруутгана гэдэг ямар бэрхшээлтэй байсан болох нь тодорхой, мэдүүлгийн хэсгээ "Монголын дотор Японы түлхээсээр" болгосон нь учиртай бөгөөд Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний түүхийг товчлон гаргасан байна. Япон улс халх монголыг эзлэх ба бүх монгол үндэстнийг эзлэх зорилгоо огт орхиогүй хэвээр явуулж байгааг нь илхэн хэлжээ.

1911-1912 оны хөдөлгөөн түүний явц, бүтэлгүй төгсгөл улмаар Бароны автономитийг хүртэл тоочин дурьдаад Монгол ардын хувьсгалын хүчин ба зөвлөлт Их улсын хүчинд цохиgidон сөнөсөн хэмээжээ. Үүнээс үзэхэд үнэхээр биеz даасан нэгдсэн их монгол улс байгууллага байсныг нотлоод байх шиг. "Энд байгаа юмыг байгаагаар нь л өгүүлсэн үнэн түүх бөгөөд ер эсэргүү гэх уг үл ажиглагдана. "Японы эзэрхэг түрэмгий нар хувьсгалын эсэргүү дайснуудаас ардын хувьсгалт засагт тэрслэн ирсэн байдлын тухай" нэрээр үнэнийг илэрхийлсэн байна.

Эхлээд монголд эсэргүү бүлгэмүүд ажиллаж байсан бөгөөд хилийн зэвсэгт мөргөлдөөн гаргахад ч хүргэжээ. Миний тоочин буй хувьсгалын эсэргүү болсон Саж лам, Бодоо, Данзан, Дамбийжанцан хийгээд улмаар Эрэгдэндагва Манзшир, Дилэв хутагт, Жамъянтив ламын болон "бас бус эсэргүү бүлгэмийн хэргүүд" гэсэн учир тэд ямарч эсэргүү, тагнуул биш, харин ч улс орныхоо бүрэн тусгаар тогтолын төлөө тэмцэгч үндэсний эх орончид болохыг үнэн хэрэг дээрээ товойлгож тавьжээ. Энэ тухай юу ч эс дурссан бол түүх түүхийрч, хойч үе маань улируулан нягтлах түүхэн баримт нэгээхэн ч үгүй үлдэх байжээ.

Япончууд дотоод монголд мөрдөн хяхдаг гол дайснаа гэж үздэг ардын нам гэгчийг ашиглан, түүний гишүүд Цэрэндондов, Алтан, барга мэргэн Бумандий, Эрхэмбат нарыг монголд ирүүлж байсан бөгөөд тэд Японы гар хөл болж явсан уу гэдэг нь аяндаа тавигдаж шүүн нягтлахыг хүлээсээр байна. 1928-1929 оны үеэс Москвад очоод байсан Дамбадорж, Дорлигжав, нартай Японы элчин сайдын яам харилцаж холбоо тогтоосон, цэргийн ятташе Таникаг монголд явуулахаар хөөцөлдөж байсан нь цөм Японы арга явууллага гэжээ.

Япончууд Түвшээс оргон гарсан Ванчин ламыг ашиглан монголын дотор өөрийн эсэргүү тагнуулын ажлыг хүчтэй явуулж, Монголын ихээхэн хутагт хувилгаадтай холбоо тогтоон ажиллаж байсныг дурьджээ.

А.Амар, мэдүүлэгтээ Япончууд хятад түвдийн оргодол худалдаачдыг тагнуул, төлөөлөгч болгон илгээж, СССР-ээс оргосон оросууд, буриад нарыг хувьсгалын эсэргүү хэрэгтээ өргөн ашиглаж, тийм хэргүүд илэрсээр байсныг тодорхой бичжээ. Япончуудын бас нэг зальхай явууллага бол монголын дээд удирдлагыг ямарч аргаар хамаагүй Японых болгох тагнуул төлөөлөгчөө гэх, Гэндэн, Дэмид, Самбуу, Ёнзор хамба нарыг элсүүлсэн "эсэргүү бүлгэмийн байгууллага"<sup>26</sup> ажиллаж байсан тухайг ч дурьджээ. Гэтэл эдгээрийн цагааталаас үзэхэд, ямарч хувьсгалын эсэргүү, үндэсний эрх ашгаа уравсан зүйл огт байхгүй

<sup>26</sup> "Үнэн" сонин. 1995. № 15 /18379/

бөгөөд харин Чойбалсангийн Сталинч бүлэглэлийг эсэргүүцэж, улс орныхоо бүрэн тусгаар тогтолын төлөө тэдний балмад харгис үйл ажиллагааг эсэргүүцсэн нь харагддаг.

Гурав дахь хэсгээ "Миний өөрийн биеэр хувьсгалын эсэргүү хэрэгт хэрхэн оролцож биелүүлж байсан тухай" хэмээжээ. Энд ердөө л өөрийн жирийн амьдралын түүх, үйл ажиллагааг хүүрнэн өгүүлэх бөгөөд өөрийн сурвалжит угсаатайгаа хэлээд З төрд алба хашиж, монголын төлөө зүтгэсээр ирсэнээз энгийнээ өгүүлэн энэ явцад бүх монгол үндэстнийг нэгтгэх тухай үзэл саналыг баримтлах болсоноо шулуухан хэлээд, ер алив эсэргүү зүйл байгаагүйгээ нуулгүй хэлжээ. Бас өөрийн үзэл бодлоо Ханд ван, хичээнгүй Цэрэндорж, Цэвээн нарын нөлөөнд төлжих ёссөнөө ч нуугаагүй байна.

Чен И-н гэрээ бичигт үсэг зурж явсанаа, бас Сюй Шү Женд баригдаж хоригдож явсанаа нуулгүй өчсөн байна. Ардын хувьсгалын үед МАН-ын эрмэлзэх 10 зүйлийг бүрэн дэмжиж, гол төлөө удирдах тэргүүлэх албандаа зүтгэж, ардын нам, засгаас авч явуулсан ноёд лам нарын эрхийг хасч хязгаарлах, хөрөнгийг хураах сүм, жас, лам нарт хүнд албан татвар ногдуулах буюу хөрөнгө малыг хураах, улсын дотор барих хорих явдал олширч, гадаад улсын болон ялангуяа хятад худалдаачдыг хавчих хязгаарлах зэрэг олон өөрчлөлтийг үргэлж татгалзан saatuulж байснаа буруу болгон хүлээжээ. Бас СССР-ээс хөндийрч, бусад хөрөнгөтөн орнуудтай өргөн харилцаж байснаа буруу болгон хүлээжээ. Түүний өгүүлсэн дээрх зүйлсээс үзэхэд эсэргүү, уравсан юм огт байхгүй бөгөөд харин үндэсний ардчилсан хувьсгалын чиг шугамаа хамгаалсан тэмцэл харагдаж байна. Үнэнийг урвуугаар илэрхийлэх гэдэг энэ буюу. Бээжин, Жанчхүү, Тянжинд харилцан туслалцах хоршооллын салбар нээж ажиллуулсанаа буруу болгожээ.

Анхаарал татаж байгаа нэг зүйл бол Зөвлөлтийн зөвлөх мэргэжилтнийг үзэн ядаж, хавчин гадуурхаж байснаа илэн далангүй өчсөн нь чухамдаа Монголын дотоод хэрэгт Орос хэт оролцож, дарамталж байгааг хэлсэн бололтой. Түүний хамт зөвлөлтийн тусламжаар асар их юм бүтээнээ, тухайлбал, аж ахуйн комбинат, хатгалын ноосны үйлдвэр, гар үйлдвэр, Налайхын чулуун нүүрсний уурхай, Налайхын төмөр зам Алтан булаг-Улаанбаатарын засмал зам зэрэг олон газартай болсоноо тов тодорхой илэрхийлсэн байх юм.

Түүний хамт өөрийн алдас болгон хөрөнгөтөн оронд 30-аад хүүхдийг явуулан сургаж, бичгийн хэвлэлийн машин ба цэмбэ нэхэх машин, төмрийн завод, туйпууны завод байгуулахад хэрэглэгдэх машин зүйлүүдийг авч арваад мэргэжилтэн нарыг урьж ирүүлэн ажиллуулсан, бүр энэ үед Налайхын чулуун нүүрсийг зөөх төмөр зам тавиулах тухай ажил явдал болгон хэлэлцэж байснаа мөлжимтгий улс оронтой ашиггүй, ихээхэн гарз чирэгдэл гаргасан гээд дутууг СССР улс гүйцээж бүтээж өгсөнийг цохон тэмдэглэжээ.

Миний бие анхнаасаа эдгээр ажлыг Германтай харилцан гүйцэлдүүлэхийн оронд СССР-ээр гүйцэтгүүлсэн бол үүнээс улам илүү амар дөхмөөр гүйцэтгүүлж болох байсан гэжээ. Өөрийгөө тэр цагт баруун болон үндэсний үзлийн үүднээс монголын феодал лам нар ба шашныг хамгаалан Зөвлөлт Их Улсаас хөндийрөх замыг эрэн, хөрөнгөтөн улсуудтай харилцан найрамдахыг хичээн монголын хувьсгалын үйл хэрэгт энэ мэтээр саад тормос болж, түүнийг нь баруун болон үндэсний үзэлтэн нар энэ мэт ажил явдлыг үйлдэлцэж байжээ.

Энд би судлаачийн хувьд, буруу гэх зүйлийг олон хараагүй. СССР-ээс хөндийрнэ гэдэг монгол орноо дэлхийн зах зээлд нээлттэй болгож өргөн харилцааг олон улс оронтой тогтоох л гэсэн зөв зүйтэй зүйл байжээ. Гэтэл тэр үеийн "хэт зүүний" балмад үзэлтэн, Оросыг дагагчид нийгмийн бүхэл бүтэн бүлэг хүч болох язгуур угсаатныг феодал хэмээн нэрлэж, тэдний улс төрийн эрхийг хууль бусаар хасаж, улмаар 1930-аад оны эхээр хөрөнгий нь ёс бусаар хурааж, оршин амьдрах үндсий нь тасалж, эцэст ангийн хувьд устгаж амь нас, гэр бүлий

нь бусниулсаныг эсэргүүцэн, цуст аллага хядлага хийлгэхгүй гэж аймшигт аюулыг урьдчилан харж, ухаарч амь насаа үл огоорон зутгэж байжээ.

Сүм хийд лам нарын асуудал гэгчийг ямагт улиглан явуулж, шүтэх бишрэх нь хүний хувийн чөлөөт эрхийн асуудал болгон тунхагласан ч нэдэр дээрээ жирийн лам хуврагуудыг гадуурхан хяхаж том лам нарыг эсэргүү болгон хутагтуудын хэрэг гэгчийг дэгдээж хэлмэгдүүлэн сүм хийдийн хөрөнгө жасыг хурааж, эцэст жирийн лам хуврагыг хомроголон хөнөөж, түүх соёлын асар их дурсгалыг үнсэн товорг болгосон ямар их училшгүй, засаж болшгүй нүгэл хилэнцийг гаргуулахгүйн төлөө чадал заан тэмцжээ. "Хэт зүүнтэн" хувийн өмч рүү өнгөлзөн алхам алхамаар халдаж албан татвар, өртөө, төлөвлөгөөт даалгавраар дарамталж байсан бөгөөд манай малчин түмэн ямар их гай гамшиг амсч хамгийн хүнд ихээр хэлмэгдсэнийг харж болно. Улс, хоршоолтын өмчийг дэмжин хөгжүүлсэн нь буруу биш, Ардын үйлдвэрлэлийн нэгдлүүд ч бий болсон нь дэвшил боловч хувийн өмчийг дэмжихийн оронд сэргүүлэн тавьж, албадан хүчирхийлэх болжээ. Энэ ёсон бус байж болшгүй гамшиг бол "Зүүнтэн" зөвлөлтийн талыг баримтлагч, Чойбалсантын хийсэн үйл ажиллагааны хорт уршиг байлаа.

Харин үүнийг эсэргүүцэн тэмцэж баруунтан, үндэсний үзэлтэн хэмээгдэн буруутгагдсан улс төрийн энэ хүч бол монголын үндэсний ардчилсан хувьсгалын чиг шугамыг хамгаалан тэмцэгчид байжээ.

А.Амар бүх монгол үндэстнийг нэгтгэн нэгэн улс байгуулахыг хүсэж явдгаа шулуун илэрхийлээд өрөнхий сайд Цэрэндорж, удирдагч нөхөд Дамбадорж, Жадамба, Цэвээнжамсранов нар ч үзэл нэг гээд тийм хүмүүс монголд олон бийг тэмдэглэсэн байна. Өөрийн баруун үзэл ажлыг ба Дамба, Жадамба нарыг ихээхэн хамгаалж, улмаар баруунтан болгосон нь зүүнтний Коминтерн, Оросын шууд оролцоотойгоор явуулсан зориудын зохион байгуулалттай намын шугамаар хийгдсэн цээрлүүлэлт болж, чухамдаа үндэсний ардчилсан хувьсгалч эх орончдод өгсөн анхны том цохилт бөгөөд энэ үеэс хувьсгалын эрч хүч супран гүйвж алдаа завхралын хар замд гулсан орсныг өгүүлж байна.

А.Амар "зүүний" нугалаа завхралын үйл ажиллагааг ч, шинэ эргэлтийн бодлогын үед ч үзэл бодол, үйл ажиллагаагаа улам эрчимжүүлсэн байна. Бүр 1920-иод оны дунд үеэс Гэндэн, Дэmid нартай холбоотой санал бодол нэгтэйгээ ойлголцож ирсэн, бас шууд элсэн орж болохгүй шалтгаанаа учирлан ойлгуулаад тэдний үүсгэж яваа энэ хэрэг ажил нь монголд ихээхэн ашиг тустай ажил болох тул та нөхөд хичээж ажиллалтун хэмээн зөвлөж, тэднийг бүх талаар бүрэн дэмжихээ илэрхийлжээ. Амарыг чухамдаа Монголын үндэсний тусгаар тогтолын байгууллагын эчнээ идэвхтэн гишүүн, оролцон зохион байгуулагч улмаар удирдагч нь болж товоиж гарсан гэж үзмээр байдаг.

А.Амарын мэдүүлэгт онцгой байр эзэлж их дэлгэрэнгүй бичсэн Монгол Японы харилцааны асуудал бөгөөд Манж лугаа хэрэг хэлэлцэж байсан Самбуугаар Японы төлөөлөгч Иногучид өөрийн нэрээр захидал илгээн "монгол улс их Япон улс лугаа харилцаа найрамдал байгуулахыг хэзээд хүссээр буй тул энэ хэлэлцээгээр үндэслэн эрх биш харилцаа найрамдал байгуулахыг хичээмой. Энэ талаар бид нар ч хичээмой" хэмээн санал бодлоо тодорхойлжээ. Хариуд нь "монгол япон хоёр нь хэзээ ч харилцаа найрамдал байгуулах болмой. Бид ч үүнийг үргэлж бодож чухалчлан байдаг ба та нар ч тэндээ сайтар бодож ажиллаж байх хэрэгтэй" хэмээжээ. Энэхүү найрсаг манж үгсийн цаанаа чухам юу нуугдаж буйг аль аль тал нь арван хуруу шигээ мэдэж байсан нь дамжиггүй.

Үйл явц ийнхүү өрнөж байтал үхлийн хар аюул дайрлаа. СССР-т явах болсон Дэmid, Амарт хандаж "би амьд ирэхгүй, үхэх болмой" хэмээн хэлсэн бөгөөд төдөлгүй Дэmidийн үхсэнийг сонсож мэдээд түүний эмгэнэн гашуудлыг ихээхэн өргөнөөр хийж өнгөрүүлсэнээ цаанаа нарийн учиртай" гэсэн санаагаа цухалзуулж амжжээ. Бас Самбууг хань болгох санаатай засгийн газрын

хоёрдугаар орлогч сайдын тушаалд томилуулан авсан боловч удсангүй гэжээ. Бүх Монгол үндэстнийг нэгтгэх японыг түшиглэж хөрөнгөтний засгийг байгуулах хэргийг хүчлэн оролдож байсан Гэндэн, Дэмид нарын бүлгэм нэгэнт илрэгдэн устаж буйг үзээд тэрхүү хэргийг залгаж уламжлах хүч үгүй болж буй учир эрх биш үүний үндсийг таслахгүй, заавал үргэлжлүүлэхийг ямагт хичээн бодох болсоноо шуудхан хэлж, түүнийг тэр үеийн монголын удирдагчид, албан хаагчдын олон хүн дэмжиж байгаад итгэж тулгуурлан түүний хэлсэнээр нэгэн арга зам байгуулахаар /тэмцлийн тодорхой арга хэмжээ/ шийдэн” хөдөлжээ.

Жич Их Япон улсыг түшиглэх бодлогыг хэлбэрэлтгүй дэвшүүлсэн нь манай төрийн уламжлалт бодлого болох нэгийн эрхшээлээс гарахын тул нөгөөг түших, нөгөөг эгээрэх замаар улс үндсээ авч үлддэг, өрсөлдөгч хүчинтүүдийн хоорондын зөрчлийг ухаалаг ашигладаг түүхэн практик сургамжаа харгалзсан нь үзтэл илэрхий байна. Байдлыг үзэж, “Нэгэн арга зам” гэдэгт итгэж болох үзэл нэгт нөхөд дотоод яамны орлогч сайд Лосол, цэргийн яамны орлогч жанжин Дамба, Сангийн яамны сайд Довчин, худалдааны яамны сайд Дорж нар түр нягт харилцан /нэр дурьдагдаж бүхий хүмүүс бол Амарын санаачилсан Гэндэн Дэмидийн хэргийг залгаж уламжлах үндсийг таслахгүй үргэлжлүүлэгч байгууллагын удирдах бүрэлдэхүүн байжээ/ хэлэлцээр Улаанбаатар хотын цэргүүд ба зүүн хязгаарын цэргүүдээр бослого гаргахаар хэлэлцэн тогтжээ. Тэд зэвсэгт бослого гаргаснаар өөрийн хөрөнгөтний засгийг байгуулах гэсэн зорилтыг гүйцэтгэж чадахгүйг эцэстээ эрх биш тустай болж болно гэж тооцоолжээ. Хүч үл хүрэх авч “Хүчин дор арга хэрэглэх” нэгэн ёс буй тул цэргүүдийн бослогыг хөдөө ардуудын дотроос дагалдан бослого гаргаж болох ба бас албан хаагчид ч зөвшөөрөн туслахаар тооцож, дотоодын бослоготой зэрэгцэн японоос дайрч ирэх болвоос гадна дотнын хүч хавсарч нэгэн явдал гарч болох ба үүнийг далимдуулан дахин шинэ эргэлтийн бодлогыг гаргаж, улмаар Япон лугаа ойртон хөрөнгөтөний засгийг байгуулж болно хэмээн шийдвэрлэн “юу ч атугай нэг хөдлөөд үзэхээр шийдвэрлэн тогтжээ”<sup>27</sup>.

Зэвсэгт бослогын тухай өөр баримт бичиг, судалгааны бүтээлүүдэд огт тааралддаггүй бөгөөд Амарын мэдүүлэгт дэлгэрэнгүй тоочин түүхийн судалгаанд цоо шинээр дэвшүүлэн гаргаж тавьжээ. Зэвсэгт бослогыг удирдах, зохион байгуулалтын талаар нарийн анхаарч босогчдын эгнээг өргөтгэх тухайн хувьсгалт засгийн хүчин явууллагыг сүл болгох арга нехцөл шалтгааныг зохион төлөвлөж гүйцэтгэхийг заагаад үүнийг Дамба, Лосол нарт даалгасан нь эд бол үнэндээ зэвсэгт бослогын удирдлагыг томилсон хэрэг байлаа. Хувьсгалт засгийн үйл хэргийг гачигдуулж боогдуулах, бослогын үед мөнгө хөрөнгөөр туслахыг сайд Довчин эрхлэх, худалдааны талаар олон албан газрууд ба ардуудыг боогдуулах, бослогод эд бараагаар хангах явдлыг сайд Доржоос эрхлэхээр тогтжээ. Харин Амар Монголын засгийн газар ба олон яамдын ажлыг удирдахдаа хувьсгалт засгийн бусад ажил хэргийг бослого гаргахуй дор тус дөхөмтэй түүнд нехцөлдүүлэн явуулах ажлыг ерөнхийд нь гардан хариуцсан нь тэрээр нэгдсэн Их Монгол улс хэмээх байгууллага, Гэндэн, Дэмидийн үйл хэргийг сэргээн үргэлжлүүлж, түүний жинхэнэ удирдагч болсон нь тодорхой харагдаж байна. Зэвсэгт бослого бодьтой бэлтгэгдэж зохион байгуулалтын хувьд нэгэнт бэлэн болсон нь тодорхой байна. Дамбатай уулзахад хот хөдөөд хань нөхөд олширч байна гээд хотод шар Найдан, Баярсайхан, штабын дарга Намсрай, хөдөөд зүүн хязгаарын корпусын дарга Цагаан бусад олон дивиз хороодын дарга комиссар нар элссэнийг мэдэгджээ. Амар ч бас зүгээр суусангүй ихэд болгоомжилж байсан ч Өмнөговь аймгийн дарга Дамба Рөнчин, Хэнтий аймгийн дарга Наваан, Булган аймгийн дарга Дорж нарыг элсүүлжээ.

<sup>27</sup> “Үнэн” сонин. 1995 №(18379)

Гэвч бослого гарч чадаагүй нь Улаан Оросын шууд оролцоотойгоор Дэмид, Малж, Дамба зэрэг цэргийнхнийг бараг нэгэн өдөр шахуу баривчилан хөнөөсөн нь бослогыг удирдлагагүй болгож чадсан байна. Улмаар Амар түүний нөхдийг дайчлан баривчилсанаар Монголын эх оронч үндэсний ардчилсан хүчнийг олноор нь хомроголон хэлмэгдүүлэлт явагджээ. Энэ тухай судлаачдийн санал дүгнэлтийг үзвэл Ж.Болдбаатар доктор "Ортодокс коммунист чиглэлийн коммунист чиглэлийнхэн гаднын хүчний оролцоотойгоор улс төрийн хэлмэгдүүлэлт хийж, өрсөлдөгчөө нухчин дарсанаар нэг хүнийг тахин шүтэх явдал газар авчээ"<sup>28</sup> гэж дүгнэсэн байна. Түүхч Л.Бат-Очир, С.Отгонжаргал нар 1921-1940 оны үед хожим ч цухалзсаар байсан монгол бие даасан гадаад бодлого тухайлбал; ЗХУ-ын дохиураар л хөдлөх төдий манай үндэсний эрх ашигт харш, их гүрний улс төр эдийн засгийн бодлого, хүчин чармайлт тухай бүр няц цохигдсон, ялангуяа 1930 оны сүүлээрх бүх нийтийн хэлмэгдүүлэлтээр ... Москвагийн дохиураар л хөдлөхөөс өөр арга бололцоо Монголчуудад байхгүй болсон<sup>29</sup> гэжээ.

Ийнхүү 1930-аад оны аймшигт жилүүдэд Монгол орны нийгэм хямралд бүрнээ автан үндэсний ардчилсан хувьсгалын чиг шугам гүйвж, урвуу харш гольдор луу хальж, монгол социализм байгуулах туршлагын, тоглоомын хөөрхий орон болжээ. Түүхч Д.Өлзийбаатарын улс төрийн хэлмэгдүүлэлт гэх нь хангалтгүй "энэ бол монгол үндэстний" удам угсаа, соёл урлаг, хэв заншил, ёс суртлыг санаатай устгах этноцид үйл ажиллагаа, хүн амын гарал үүсэл, шашин шүтлэг, үзэл суртлын зөрүүгээр аймаглан устгаж, гэр бүл, үр хүүхэд хамаатан садныг нь хавчин гадуурхан эд хөрөнгө, амьдрах эрх рүү халдан довтолсон төрлөөр устгах гэмт хэрэг /геноцид/" гэж үзсэн шинэлэг санаа дүгнэлттэй бүрэн санал нийлж дэмжиж байна.

1937-1940 он хүртэл 26721 хүн шийтгэж түүний 20660 хүн нь буюу 77 хувь нь буудуулсан байна. Хилс хэрэгт ястан үндэстний бүрэлдэхүүнээр авч үзвэл халх 20020, буриад 2896, хятад 1633, хасаг 527 байв<sup>30</sup>. Энэ аюулыг Амар, түүний үзэл нэгтэн өвөг дээдсийн агуу ухааныг залгамжлан урьдчилан харж чадаад амь наасаа зориулсаныг хэлэх нь зөв болов уу. Гэвч тэр нэرت тэмцэгчид, эх оронч үндэсний хувьсгалчдыг нухчин дарсан ч, Монголын үндэсний эх оронч үзлийг дарж чадаагүй юм. А.Амар мэдуулгийнхээ 4 дэх хэсгийг "Японы эзэрхэг түрэмгий нар ба хувьсгалын эсэргүү нараас Монголд учруулж байсан хор хохирол ба түүнийг бүрмөсөн тасалж цэвэрлэх тухай хэмээн хараад их л тал засаж гоёж гоодсон Орост үнэнчийн дүр эсгэсэн нэр өгсөн мэт авч доторхийг нь нягтлахад эрс өөр дүр төрх тодорно.

Өнгөрсөн түүхээ дэнслэн улс орон дэлхийн хөгжлөөс хоцорсоны шалтгааныг гаргаад Манж Хятадаас тусгаарлан салж, автономит улс байгуулсан хэмээсэн нэр буй боловч гал усны гашуун зовлонгоос ангижирч чадаагүй тэр нь гадаад дотоод хүчин зүйлүүд цагаан Оросын ба хаант засаг, түүний үлдэгдэл харгис генерал түшмэл, цэргүүдийн хатуу бэрх зовлон дарлагдлыг хүлээж тэсэх аргагүйд хүрснийг тодорхой өгүүлжээ. Тэр цагт ард түмнийг энэрч аврах хүмүүс алинд ч огт байсангүй гээд харин тийн атал өөрийн жинхэнэ ардын хөвгүүд Сүхбаатар, Чойбалсан тэргүүтэй монголын ард түмэн нь өөрсдөө хүчлэн зүтгэж Зөвлөлт их улсын тусlamжтайгаар гадаадын дайснуудыг хөөн зайлуулж, өөртөө бүрэн эрхтэй хувьсгалт засгийг байгуулсан, өнгөрсөн 18 жилийн туршид зөвлөлтийн тусlamжтайгаар маш их хөгжиж бэхжиж ирсэн гэжээ. Түүний хамт японы эзэрхэг түрэмгий нар ба дотоодын феодал лам нар хийгээд хувьсгалын эсэргүү нар нь тус улсын хувьсгал ба хөгжилд ямагт саад боомтыг учруулсаар, ... хорлож саатуулаагүй байсан аваас манай улс нь үүнээс маш илүү

<sup>28</sup> Монгол улсын түүх. УБ. 1999. т.199

<sup>29</sup> Л.Бат-Очир, С.Отгонжаргал "XX зууны монгол дахь улс төрийн түүхэн үйл явц". УБ. Т. 35

<sup>30</sup> Монгол улсын түүх. УБ. 1999. 136 тал

хөгжил бэхжилтэй байх ёстой агсан амой хэмээсэн нь өөр зуураа зөрчил агуулсан нь мэдэгдэж байна. Тэрээр тухайн цагийн Монголыг Японы гадаад талаас элдэв хандлага довтолгоонд эрсдэж, япончууд өөрийн тагнуул төлөөлөгчөө олноор оруулан, дотоодын эсэргүү этгээдийг ашиглан Монголын эрдэм соёл, аж ахуйг элдэв арга явуулгаар саатуулан боогдуулж, эвдэх, сүйтгэх, шатаах зэргээр элдэв хор хөнөөлийг учруулан жирийн албан хаагчид, ардуудыг өдий төдийгөөр холбогдуулан түүний уршгаар улсын дотор баривчлах, дайчлах цус урсгах явдал ямагт тасралтгүй гаргаж, эзэрхэг японы халдлага довтолгоог няцаах, эсэргүү тагнуул дайсан этгээдүүдийг тагнан илрүүлэх, баривчлах хэрэгт ихээхэн хохирол сүйтгэл үзэж буй хорлон сүйтгэлийн гарз чирэгдэл маш их болсон гэжээ. Монгол улс нь энэ мэтийн бузар муухай явдлын оронд өөрийн хөгжил бэхжлийн ажлыг гүйцэтгэж байсан аваас манай улс нь үүнээс хэдэн давхар илүү хөгжиж бэхжих ёстой байсан хэмээн үнэлэлт дүгнэлт өгчээ.

Гэндэн, Дэмид, Ёндон нарын эсэргүү бүлгэм, түүний үлдэгдлийг хурц сэргэлэнээр арилгасаар боловч түүний эцэс өроол нь огт үзэгдэхгүй, түүний бүгшсан идээ бээр нь шавхагдаж гаргагдахгүй нуугдан үлдэж хоцрогдох буюу нам өрсөж дэлгэрэх тухай их л сэтгэл зовнин нэг нь илрэвч нэг буюу хэд хэд нь үлдэж хоцрохоор хэдэн арван буюу хорь гучин хэсэг бүлгэмээр бие биест мэдэгдэхгүй явуулахаар бодож явуулах ёстой хэрэг тул миний буюу бидний мэдэхгүй эсэргүү үзэлтэн ба бүлгэмүүд эрхбиш үлдэж хоцорсон байх нь магад буй гэж сэргэлжүүлсэн аястай санаагаа гаргасан байх юм. А.Амар өөрийгөө илчлэн 18 жил Монголын хувьсгалын хэрэгт зүтгэж нэр алдрыг олон эдүгээ хэр зах жишээ нь засгийн газрын ерөнхий сайд хэмээж байсан миний бие нь өөрийн эсэргүү ажлыг илэрүүлэхгүй нуун дарагдуулж, Монгол үндэстнийг нэгтгэх хэмээх үндэсний үзэл ба японыг түшиглэж хөрөнгөтний засгийг байгуулах бодлогыг баримтлан эсэргүү бослого гаргахаар оролдож байсан ба бас ч миний адилын үзэлтэн ба эсэргүү ажилтан надтай хамт ажиллаж байсаар саяхан илрэгдэн баригдсаныг дурдахын хамт бидний адилын ийм этгээдүүд маш олноор үлдэн үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна гэж тэмдэглэсэн нь тэрээр зүтгэл хичээлээ зөвийгөө буруутган зөвтгөх хэлбэрээр илэрхийлжээ. 18 жилийн турш үнэний төлөө Монголын төлөө зүтгэж ирсэнээ илтгэн тавьжээ. Хэн нэг нь өөрийн эх оронд хайртай ба хэн нэгэн Монголоо бодогч, хэн нэгэн үлэмж баривчлал үлэмж цус урсах явдал арилсугай хэмээгээд хэн нэгэн амар тайван байдлыг хүсэгч хүмүүн нь энэ бэрх явдлыг эцэслэн зогсооход зориулан өөрийн гэм муу явдлаа илчилж, мунхаг сохор үзлээсээ бүрмөсөн эцэслэн тасалж өөр нүүр царай ажил явдлаа /шинэ нөхцөлд шинэ арга хэлбэрээр ажиллах/ өөрийн эх орон, өөрийн улс үндэс, өөрийн хувьсгалын ажлын зүг тийш хандуулан хэрэгтэй болсон тул миний бие өөрийн баримталж байсан гэмт үзэл ажлаа бүрмөсөн илчилж таслахаар нэгэнт эрс тод шийдвэрлэн ялангуяа үүнээс цааш Монголын дотор аливаа нэгэн баривчлах ба цус урсгах явдлыг зогсоож ард түмнийг амгалан тайван байлгах явдлыг хичээн чухалчилж энэ бодлого саналыг гүйцэтгэхэд тус болоход зориулан японы эзэрхэг түрэмгий нараас Монгол үндэстнийг нэгтгэх хэмээх хуурамч лозунгоор бүрхэгдүүлэн Монголыг эзлэн авах тухай ямар бодлого явуулж ирсэн ба ялангуяа Монголын хувьсгалт засгийг эвдэн устгах тухай ямар бодлого явуулж ирсэн ба ялангуяа Монголын хувьсгалт засгийг эвдэн унагах тухай эсэргүү тагнуулын ажлыг хэрхэн явуулж ирсэн байдлаас өөрийн онож мэдсэний хэрээр илтгэл гаргасан бөгөөд бид одоо Монголын ард түмнийг ашиг тусыг бодохгүй болвоос өөр бodoх цаг олдохгүй ба бид одоо өөрийн гэм буруугаа хүлээж өөрийн нэр бивийг цэвэрлэхгүй болвоос өөр цэвэрлэх цаг ирэхгүй тул миний адил үзэлтэн ба эсэргүү ажилтан тийм нөхөд байваас хамаг буруу муу үзэл, ажил, гэмээ илчлэн японы халдварт эсэргүү тагнуулын хорт тариаг үр үндэс тэргүүтний хамт нэг мөсөн шүүрдэн цэвэрлэж, Монголын их хувьсгалын ажил үйлст бүгд нэгэн санаа, нэгэн хүчээр зүтгэлцэн их тус болохыг

миний нэгэн адилын бусад нөхөдөд үлгэр дууриал болохыг би ихэд хүсэж байна хэмээн мэдэгдлээ дуусгаж тэмцэлд уриалан дуудсаныг уг бүрчлэн тэр чигээр нь толилууллаа<sup>31</sup>

**Abstract:**

Prior to 1940, the two antagonistic political fractions competed for prominence in Mongolia. This article names political figures as G.Demid, P.Genden and A.Amar as the leaders of the nationalist-democratic camp. These people represented the second generation of leaders carrying the ideals of the 1921 national democratic revolution. In striving for the unification of the entire Mongolian ethnies, they preferred to align with the rising power of Japan and upon that reliance and to intensify the Mongolia-Japanese ties. They were earnestly seeking to oust the brutal regime by instigating the armed uprising and letting the Japanese troops in via the border port of Zamyn Uude. This fraction's political agenda was to uphold the capitalist way of.

---

<sup>31</sup> "Үнэн" сонин. 1995 № 15 (18379/